

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.03.10

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Төв банкны дарга Жером Пауэлл хүүгийн түвшинг хэвээр үлдээх бодолтой байгаагаа илэрхийлэв.
- АНУ-ын хөдөлмөрийн зах зээлд 151,000 ажлын байр шинээр бий болсон нь хүлээлтээс бага үзүүлэлт байлаа. Үүний зэрэгцээ ажилгүйдлийн түвшин 4.1 хувь болж бага зэрэг өссөн.
- Tesla Inc (NASDAQ:TSLA) компанийн байгууламжууд АНУ болон Европ даяар эсэргүүцлийн жагсаал, эвдлэн сүйтгэх үйлдлийн бай болоод байна.
- Хятадын хэрэглээний үнийн индекс (CPI) 2025 оны 2-р сард -0.7% болж, 13 сарын дараа анх удаа сөрөг үзүүлэлттэй гарлаа.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Зураг: Теслагийн автоамшиныг Европт Boycott-лож эхэллээ. Теслагийн загварууд Европын замаар давхих эсэх нь сорилж боллоо





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.03.03-03.09

БОДЛОГЫН ХҮҮГ ХЭВЭЭР ҮЛДЭЭНЭ



Төв банкны дарга Жером Пауэлл хүүгийн түвшинг хэвээр үлдээх бодолтой байгаагаа илэрхийлэв. Тэрбээр АНУ-ын эдийн засаг тогтвортой хэвээр байгаа ч тодорхойгүй байдал өндөр байгааг онцолж, бодлогын хүүг буулгахаас өмнө илүү тодорхой эдийн засгийн дохио хүлээх нь зүйтэй гэж үзэж буйгаа мэдэгдлээ. Мөн Дональд Трампын сүүлийн үеийн эдийн засгийн бодлогын өөрчлөлтүүд, тухайлбал тарифын өсөлт болон төрийн ажилчдын цомхотгол зэрэг нь эдийн засагт тодорхойгүй байдал үүсгэж буйг тэмдэглэв.

Сүүлийн үеийн эдийн засгийн үзүүлэлтүүд холимог дүр зурагтай байна. Хоёрдугаар сард АНУ-ын хөдөлмөрийн зах зээлд 151,000 ажлын байр шинээр бий болсон нь хүлээлтээс бага үзүүлэлт байлаа. Үүний зэрэгцээ ажилгүйдлийн түвшин 4.1 хувь болж бага зэрэг өссөн. Эдгээр тоон мэдээллээс үл хамааран хөдөлмөрийн зах зээлийн эрэлт буурч, ажлын байрны цомхотгол нэмэгдэх вий гэсэн болгоомжлол хэвээр байна. Холбооны Нөөцийн банкны үндсэн хоёр зорилт болох инфляцыг тогтвортой түвшинд хадгалах, ажил эрхлэлтийг дэмжих зорилтууд тодорхойгүй нөхцөл байдлын улмаас сорилттой тулгарч байна. Иймээс Пауэлл эдийн засгийн нөхцөл байдал илүү тодорхой болсны дараа бодлогын шийдвэр гаргах нь чухал гэдгийг онцоллоо.

Одоо хөрөнгө оруулагчид хэрэглээний үнийн индексийн тайланд анхаарлаа хандуулж байна. Энэхүү тайлан нь Холбооны Нөөцийн банк гуравдугаар сарын 18-19-нд хүүгийн бодлогын шийдвэр гаргахаас өмнөх чухал мэдээлэл юм.

ТЕСЛАГИЙН БОРУУЛАЛТ БУУРЛАА



Tesla Inc (NASDAQ:TSLA) компанийн байгууламжууд АНУ болон Европ даяар эсэргүүцлийн жагсаал, эвдлэн сүйтгэх үйлдлийн бай болоод байна. Энэ нь гүйцэтгэх захирал Илон Маск ерөнхийлөгч Дональд Трампын засаг захиргаанд, ялангуяа Төрийн удирдлагын үр ашигтай байдлын департамент (DOGE)-д нөлөө үзүүлж буйтай холбоотой. АНУ-ын Портланд, Чикаго, Нью-Йорк хотуудад Tesla-гийн үзэсгэлэнгийн танхимын өмнө эсэргүүцлийн жагсаал болж, тус компанийн байгууламж, автомашинуудыг эвдлэн сүйтгэх үйлдлүүд бүртгэгджээ. Энэ үзэгдэл Европт ч давтагдаж, Герман, Франц, Португалд ижил үйл явдлууд өрнөсөн байна.

Жагсагчид Маск болон Трампыг “фашист” үзэл суртал түгээж байна хэмээн буруутгаж, DOGE-оос хэрэгжүүлж буй ажлын байрны цомхотгол, төсвийн таналтын эсрэг байр сууриа илэрхийлжээ. Маскийн эсрэг эсэргүүцэл Tesla-ийн борлуулалтад сөргөөр нөлөөлж байна. Түүний цахилгаан автомашинуудын гол худалдан авагчид либерал, зүүний үзэлтэй хэрэглэгчид тул улс төрийн нөхцөл байдал компанид эрсдэл дагуулж болзошгүй. Үүнтэй зэрэгцэн Хятад, Европын зах зээлд BYD (HK:1211), SAIC Motor зэрэг өрсөлдөгчид Tesla-ийн нөлөөг бууруулж байна. Европ дахь борлуулалт өнгөрсөн сард 45%-иар унасан бол өрсөлдөгчдийн борлуулалт өссөн үзүүлэлттэй гарчээ.

Компани хуучирсан загваруудаа шинэчлэхийн сацуу хиймэл оюун ухаан, бие даасан жолоодлого, роботын үйлдвэрлэл зэрэг салбарт хөл тавиад байна. Гэхдээ эдгээр шинэ төслүүд эхэн шатандаа байгаа тул Маскийн нэр хүндийн уналт компанийн ирээдүйд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй хэвээр байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.03.03-03.09

ХЯТАДЫН ИНФЛЯЦ 13 САРЫН ДАРАА АНХ УДАА СӨРӨГ БОЛЛОО

Хятадын хэрэглээний үнийн индекс (CPI) 2025 оны 2-р сард -0.7% болж, 13 сарын дараа анх удаа сөрөг үзүүлэлттэй гарлаа. Энэ нь зах зээлийн хүлээлтээс илүү их буурсан үзүүлэлт бөгөөд хүнсний бүтээгдэхүүн, архи, тамхины үнийн уналт голлон нөлөөлсөн байна. Энэхүү инфляцийн уналт нь Хятадын дотоодын эрэлт сул хэвээр байгаагийн илэрхийлэл бөгөөд эдийн засгийн сэргэлт удааширч буйг харуулж байна.

Тус улсын Засгийн газар 2025 онд 5%-ийн өсөлтөд хүрэх зорилго тавьсан ч, инфляцийн зорилтыг өмнөх 3%-аас 2% болгон бууруулсан нь эдийн засгийн тогтворгүй байдлын илрэл болж байна. Үүнээс гадна АНУ-Хятадын худалдааны маргаан, үйлдвэрлэлийн салбарын сулрал зэрэг нь өсөлтийн төлөв байдалд нэмэлт дарамт болж байна.

ХЯТАД 2025 ОНД 5%-ИЙН ӨСӨЛТИЙГ ЗОРЬЛОО

Хятадын засгийн газар 2025 онд ДНБ-ний өсөлтийг 5% орчим байлгахаар зорьж, дотоодын эрэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, худалдааны эрсдэлийг даван туулах бодлогыг танилцууллаа. Энэ нь АНУ-тай улам бүр хурцдаж буй худалдааны маргаан, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт, сул инфляцийн орчинд эдийн засгаа тогтворжуулах зорилготой алхам юм.


Гэвч Хятадын төсвийн алдагдал ДНБ-ний 4%-д хүрч, 2010 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрэв. АНУ-Хятадын худалдааны зөрчил хурцдаж, АНУ-ын 20%-ийн тарифын хариуд Хятад 15%-ийн татвар, экспортын хязгаарлалт, найдваргүй компанийн жагсаалт гаргав. Санхүүгийн дэмжлэг нэмэгдсэн ч эдийн засгийн өсөлтийн зорилтыг биелүүлэхэд хүндрэлтэй байна. Худалдааны маргаан, дотоодын сул эрэлт, үл хөдлөх хөрөнгийн хямрал нь эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй.

ШИНЭ ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ ШИНЭ ХУУЛЬ

Ерөнхий сайд Ли Цян энэ жилийн засгийн газрын тайланд "том хэмжээний AI загваруудын өргөн хэрэглээг дэмжих" нь улс орны тэргүүлэх зорилтын нэг болохыг онцолсон. Үүний хүрээнд AI-тай холбоотой роботик, биотехнологи, 6G технологид нэмэлт санхүүжилт олгох бодлого баримталж байна.

Мөн Хятад Улс шинэ технологийн салбарт хувийн хэвшлийг дэмжих шинэ хууль боловсруулж байгаа бөгөөд AI хөгжүүлэлтийг нээлттэй эх сурвалж дээр суурилан хөгжүүлэхийг уриалсан.

Ихэнх Хятадын тэргүүлэх компаниуд 50% болон түүнээс дээш хэмжээгээр уналтад орсон хэдий ч санхүүгийн хувьд тогтвортой, орлого, ашиг өндөртэй хэвээр байна. Түүнчлэн Засгийн газар 3-р сард эдийн засгийг дэмжих шинэ бодлогын арга хэмжээнүүдээ танилцуулах төлөвтэй.



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
March 03, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
NOVA sunnova	SMR NUSCALE	TGT TARGET	CRWD CROWDSTRIKE	ANF Abercrombie & Fitch	MVRL MARVELL	JD JD.COM	AVGO BROADCOM	GENESCO	
HUT HUT 8	GTLB GitLab	BBY BEST BUY	CRDO CREDO	FL Foot Locker	RGTI rigetti	CBRL Fackr Barrel	BBAI BIGEAR.AI	AQN Algonquin	
PLUG plug	OKTA okta	SE sea	JWIN NORDSTROM	OPFI OppFi	ZS zscaler	KR Kroger	COST COSTCO WHOLESALE	WHF WHITEHORSE FINANCE	
TGTX TG Therapeutics	ASTS AST SpaceMobile	AZO AutoZone	STEM stem Energy Superintelligence	SSYS stratasys	MDB mongoDB	BJ BJ's	GAP Gap Inc.	YPF YPF	
AVDL Avadel	GCT GIGACLOUD TECHNOLOGY	EVGO EVgo	ORIN ORION GROUP HOLDINGS	THO THOR	VEEV Veeva	DCTH Delcath SYSTEMS, INC.	HPE Hewlett Packard Enterprise	INTT INTEST Corporation	
BUR Burford	ADMA ADMA BIOLOGICS	PSFE Paysafe	BOX box	RSKD riskified	VSCO VICTORIA'S SECRET	BKSY BLACK SKY	SERV serve	LPWD LIFEWARD	
SPHR sphere	DAVE dave	ESPR ESPERION	ROST ROSS DRESS FOR LESS	YUM YUM	TREE lendingtree	BTSG BRIGHTSPRING HEALTH SERVICES	IOT samsara	ADV ADVANTAGE SOLUTIONS	
NABL N-ABLE	SENS Senseonics	GENI Genius SPORTS	SQM SQM	ARBE arbe	GPRK GEO PARK	NINE Nine	COO Cooper Companies	ONCY ONCOLYTICS BIOTECH INC	
NMRA Neumora	EBS emergent	ONON g	KIDS CinthoPediatrics	EDIT editas	KGS KODIAK OIL SERVICES	HPO Hippo	GEVO gevo		
RC READY CAPITAL	MRC MRC Global	NYAX Nayax	FLUT Flutter	SMRT SmartRent	FSM FORTUNA	CNO Canadian Natural	CTSO CytoSorbents		
http://eps.sh/cal						© 2025 Earnings Whispers			

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
March 10, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	Before Open
BNTX BIONTECH	ORCL ORACLE	KSS KOHL'S	SMSI SMITH MICRO SOFTWARE	ZIM ZIM	ADBE Adobe	QTS Q:wave	DOCU DocuSign	LI 理想	
FNV Franco-Nevada	ASAN asana	DKS DICK'S SPORTING GOODS	HRTG HERITAGE INSURANCE	ARC Arcos Dorados	PATH UiPath	DG DOLLAR GENERAL	ULTA ULTA BEAUTY	BTBT BIT DIGITAL	
NPWR NETPOWER	PAY Paymentus	VIC VIKING	MXCT MaxCyte	IRBT iRobot	S SentinelOne	WB 新浪微博 weibo.com	MNR MACH NATURAL RESOURCES	GOGO gogo	
FENC FENNEC PHARMA	FTK FLOTEK	UNFI UNFI	SPIX STITCH FIX	MX Magnachip	PHR Phreesia	CION CION INVESTMENTS	GRWG Generation	WRD WRD	
DRO DARIO	MTN VAIL RESORTS	CEN ciena	ASM AVINO	AMRN AMARIN	CCI CROWN CASTLE	FUTU FUTU	SMTC SEMTECH	WOW WOW!	
ALGS ALIGOS THERAPEUTICS	HSAI HESAI	BWAY BrainsWay	VTS Vitesse	CKM sprinklr	AEO AMERICAN EAGLE OUTFITTERS	SOHO SOTHERLY	KINS KINGSTONE	AIRS AirSculpt	
URGN UroGen	AUNA auna	FERG FERGUSON	GRPN GROUPOIN	ONDS ONDAS	AEYE audioeye	BLDP BALLARD	LRFC LOGAN RIDGE	HSON Hudson	
TLS Telos	GAIA GAIA	DOUG Douglas Elliman	CASY Casey's	MOMO 華文集團	ECOR electroCore	BBW WORKSHOP	PTMN PORTMAN RIDGE	DTI DRILLING TOOLS	
	LFMD LifeMD	FCEL FuelCell Energy	BWMN Bowman	WDHI 水滴	TLYS TILLYS	RCMT RCM Technologies	BLNK blink		
	LCTX LINEAGE	LEGN LEGEND BIOTECH	FOA FINANCE OF AMERICA	EH EH	COLX cardlytics	UCL uCloudlink	SOL emerem		
http://eps.sh/cal						© 2025 Earnings Whispers			